



**ХЭНГИЙ АЙМГИЙН ОМНОДӨЛГӨР СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2026 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 08

Өмнөдөлгөр сум

“Ононгийн халуун рашааны ашиглалт,  
хамгаалалтын горим”-ыг батлах тухай


Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсэг, 35 дугаар зүйлийн 35.1.14 дэх заалт, Усны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит Аравдугаар хуралдаанаас **ТОГТООХ НЬ:**

1. Усны нөөцийг хамгаалах, зохистой ашиглах зорилгоор “Ононгийн халуун рашааны ашиглалт, хамгаалалтын горим”-ыг хэвсрэлтээр баталсугай.

2. “Ононгийн халуун рашааны ашиглалт, хамгаалалтын горим”-ыг хэрэгжүүлэн ажиллах менежментийн төлөвлөгөөг боловсруулан Батширээт сумын Засаг Даргатай хамтран хэрэгжүүлэн ажиллаж тайланг жилийн эцэст иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнахыг сумын Засаг дарга /Р.Энхтөр/-д даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин аялал жуулчлалын асуудал эрхэлсэн хороонд үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.НҮРЭВДОРЖ

D.disc /alban bichig/ ITH togtool

232600100

## ОНОНГИЙН ХАЛУУН РАШААНЫ АШИГЛАЛТ, ХАМГААЛАЛТЫН ГОРИМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1. Энэхүү горим нь төр захиргааны болон байгаль хамгаалах бусад байгууллага, рашаанд эмчилгээ сувилгааны зориулалтаар ирж бараалхах, аялах, амрах зориулалтаар зорин ирэх иргэд, рашааны хамгаалалтын бүсэд явуулах үйл ажиллагааг тухайн газрын менежментийн төлөвлөгөө, хамгаалалтын горим дэглэм, түүний нутаг дэвсгэрийн онцлогтой уялдуулан зохицуулахад оршино.

2. Ононгийн халуун рашаан \ цаашид рашаан гэх \ түүний орчимд явуулах аливаа үйл ажиллагааг Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, Соёлын өвийн тухай хууль, Усны тухай хууль, Рашааны ашиглалт, хамгаалалтын менежментийн төлөвлөгөө болон энэ горимд нийцүүлэн зохицуулан зохион байгуулах ажлыг сумын ИТХурлаас, холбогдох байгууллагад хариуцуулан гүйцэтгүүлнэ.

3. Рашааны хамгаалалтын бүсэд явуулах аливаа үйл нь тус газрын хамгаалалтын горимыг чандлан сахиж байгаль орчны тэнцвэрийг хадгалах, усны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, ховор, ховордсон ан амьтдыг өсөж үржих таатай нөхцөл, орчныг бүрдүүлэх шаардлагад нийцсэн байна.

4. Энэхүү горимыг рашаанд эмчилгээ сувилгааны зориулалтаар ирж бараалхах, аялах, амрах зориулалтаар зорин ирэх иргэд дагаж мөрдөх үүрэгтэй.

5. Шаардлагатай гэж үзвэл Рашааны хамгаалалтын бүсэд Монгол Улсын Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн хүрээнд дагаж мөрдөх хамгаалалтын тусгай горимыг тогтоох асуудлыг сумын ИТХурал шийдвэрлэнэ.

6. Горимын хэрэгжилтэд Өмнөдэлгэр сум, Батширээт сумдын Засаг дарга болон тус сумдын Байгаль орчны улсын байцаагч нар, байгаль хамгаалагчид, ХХУТХГазрын байгаль хамгаалагч нар хяналт тавина.

### Хоёр. Ашиглалт, хамгаалалтын горим

2.1 Байгалийн болон бусад нөлөөллийн улмаас бий болсон сөрөг нөлөөлөл, хор уршгийг арилгахтай холбогдсон нөхөн сэргээх арга хэмжээг байгальд сөрөг нөлөөгүй болон рашааны орчны төлөв байдалд сөрөг нөлөөгүй арга хэлбэрээр хэрэгжүүлэх

2.2 Рашаантай холбоотой судалгаа шинжилгээний ажлыг байгаль орчин болон рашааны орчны төлөв байдалд сөрөг нөлөөгүй арга хэлбэрээр ХХУТХГазрын захиргаа эсвэл Онон Ула голын сав газрын захиргаатай байгуулсан гэрээний үндсэн дээр хийх

2.3 Рашаанд эмчилгээ сувилгааны зориулалтаар ирж бараалхах, аялал, амрах зориулалтаар зорин ирэх иргэд, зөвхөн тогтоож өгсөн газарт зохих журмын дагуу байрлах, рашаанд бараалхах, амрах

2.4 Рашааныг бохирдолоос хамгаалах, лайдах, хуучин худгийг нөхөн сэргээх зэрэгт ХХУТХГазрын захиргаа, сумын ИТХуралд мэдэгдэж хамтран ажиллана

2.5 Рашаанд аялал зугаалга хэлбэрээр зорин ирсэн иргэдийг рашаанчдаас тусдаа тусгайлан заасан талбайд байрлуулна.

2.6 Рашаанд бараалхах хугацаа 12-р сарын 01-ний өдрөөс 04-р сарын 01-ний өдөр хүртэл байна.

2.7 Рашааны даацад тохируулж нэг ээлжинд бараалхах хүний тоог тогтоох \ 30-40 хүн байна \

2.8 Рашаанд бараалхах иргэд цахимаар бүртгүүлж нэвтрэх эрхийн бичиг авна

2.9 Рашаанд бараалхагчдын авах тасалбарын загварыг менежмент хариуцагчийн батлагдсан загвараар мөрдөнө.

2.10 Рашааны даац, үйлчилгээний талаархи мэдээллийг нэгдсэн мэдээллийн сан үүсгэн цахим хэлбэрээр нийтэд сурталчилна.

2.11 Рашаанд бараалхагч иргэдэд зөвлөгөө зөвлөмж өгөх, тэдэнд эрүүл мэндийн үзлэг хийх зорилгоор ахмад эмч нарыг ажиллуулж болно.

2.12 Рашаанд бараалхах дэг жаяг, мэдээ мэдээллийг танилцуулга самбараар байр болгонд байршуулах, гарын авлага хэлбэрээр иргэдэд өгнө.

2.13 Рашаанд бараалхагч иргэд, амрагчдын аюулгүй байдлыг хангах, дэгийг сахиулах, рашааны хамгаалалтын бүсийн тохижилтыг хариуцсан "Дэг сахиулагч" ажиллуулна.

2.14 "Дэг сахиулагч"-ийг менежмент хариуцагч томилон ажиллуулна.

2.15 "Дэг сахиулагч" нь рашаанчид болон аялагчдыг тус тусын байранд байрлуулах, дэг жаягийг танилцуулах, хяналт тавих, рашааны тохижилт, цэвэрлэгээг хариуцах, хог хаягдлыг суурин газарт тээвэрлүүлэх зэрэг ажлыг хийх ба рашаанд бараалхаж буй болон аялагчдын түлээ түлш бэлтгэх талбайг зааж өгнө.

2.16 "Дэг сахиулагч" нь рашаанчид, аялагчдын мэдээллийг нэгтгэн мэдээллийн санд байршуулна.

2.17 "Дэг сахиулагч" нь онцгой тохиолдолд ХХУТХГазрын захиргаа, Өмнөдэлгэр сумын болон Батширээт сумын ЗДТГазарт холбогдон мэдээ өгөх

## Гурав. Төсөв, төлбөр хураамж, зарцуулалт

3.1 Халуун рашаан нь "Рашаан тохижуулах сан"-тай байна. Рашаан ашигласны төлбөр, хураамж тухайн сангаар дамжуулан рашааны хамгаалалт, менежментийн зардалд ашиглана.

3.2 Рашаанд бараалхагч иргэдийн хоногийн зардлыг Усны тухай хууль, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулиар зохицуулна.

3.3 Рашааны саңд дараах хэлбэрээр хөрөнгө төвлөрүүлнэ. Үүнд:

3.3.1 Орон нутгийн төсөв

3.3.2 Рашааны төлбөр, хураамж

3.3.3 Аялал жуулчлалын болон бусад ажил үйлчилгээний орлого

3.3.4 ААНэгж, иргэдийн хандив, тусламж

3.4 Сангийн хөрөнгийг дараах үйл ажиллагаанд зарцуулж болно. Үүнд:

3.4.1 Ахмад эмчид урамшуулал олгох

3.4.2 Хог тээвэрлэх зардал

3.4.3 Зам хэргүйг засах, хамгаалалтын бүсэд тэмдэг тэмдэглэгээ хийх

3.4.4 Рашааны хийдэд ном хурах зардал

3.4.5 Рашааны нөхөн сэргээлт, лайдах зардал

3.4.7 "Дэг сахиулагч"-ийн хоолны зардал

3.4.8 Холбоо харилцаа, бичиг хэргийн зардал

### Дөрөв. Бусад

4.1 "Рашаан тохижуулах сан"-г захиран зарцуулах сангийн зөвлөл байна.

4.2 Зөвлөлийн бүрэлдэхүүнийг ХХУТХГЗахиргаа, сумын ЗДТГазар, иргэдийн төлөөллөөс оролцуулан ИТХ-аар батлуулан ажиллана.

4.3 7.Горимын хэрэгжилт, рашааны үйл ажиллагаа, санхүүгийн тайланг дараа оны 1 сард багтаан ХХУТХГазрын захиргаанд болон сумын ИТХуралд тайлагнана.

4.4 Рашаанчид, аялагчид зөвшөөрөгдөөгүй газарт дураараа отоглохыг хориглоно.

4.5 Завшааралгүй буюу эрхийн бичиггүй иргэдэд байр олгохгүй

4.6 Хууль, дүрэм зарчигчдөв хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.